

Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх



Та нарын баяр хөөр хэчнээн агуу билээ

Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг зүрх сэтгэлдээ хүлээн авахад нь бусдад туслахаас илүү сайхан, удаан үргэлжлэх баяр хөөр энэ амьдралд цөөхөн билээ. Энэхүү баяр хөөрийг Сүмийн гишүүн бүр хүлээн авах боломжтой. Бид баптисм хийлгэхдээ “[бид] ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсоход бэлний учир, [бид] мөнх амьдралыг авч болохын тулд, [бид] Бурханаар гэтэлгэгдэж, анхны амилуулалтын тэдний дунд тоологдож болохын тулд буюу” (Мозая 18:9) гэсэн амлалт өгдөг.

Сүмийн гишүүд амьдралынхаа туршид Есүс Христийн сайн мэдээг дэлхийд түгээх үүргийг хүлээдэг. Их Эзэн: “Болгоогтун, хүмүүст гэрчлэх хийгээд сэрэмжлүүлэхээр би та нарыг илгээсэн билээ, мөн сэрэмжлүүлэгдсэн хүн болгон хөршөө сэрэмжлүүлэх нь хэрэгтэй болой” (С ба Г 88:81) хэмээн тодорхой хэлжээ. Бүрэн цагийн номлогч нар хараахан Сүмийн гишүүн болоогүй хүмүүст заах боломжтой. Сүмийн гишүүд нь Их Эзэний бэлдсэн хүмүүсийг олж номлогчдоод туслах хүчтэй байдаг.

Их Эзэн бидний эргэн тойронд хичээл заалгах хүмүүсийг бэлдсэн гэдэг итгэлээ, ажил хэрэг болгох ёстой. Тэрээр, тэд хэн болохыг мөн хэзээ бэлэн

болохыг нь мэддэг бөгөөд Ариун Сүнсний хүчээр дамжуулан биднийг удирдан сургаал сонсохыг урихад тусалдаг. 1832 онд нэгэн номлогчид өгсөн Их Эзэний амлалт нь номлогчдоор заалгахад бэлэн болсон хүмүүсийг олох явцад бидэнд өгөгддөг: “Мөн үнэнийг хийгээд хаашаа явах замыг нь түүнд заах Тайтгаруулагчийг бибээр түүнд илгээх болно. Мөн тэрээр итгэлтэй байхын хэрээр, би түүнд тариан боодлуудаар дахин титэм хүртээх болно” (С ба Г 79:2–3).

Итгэлтэй номлогч нарт амлагдсан агуу баяр хөөр нь номлолын ажилд зүрх сэтгэлээ зориулсан итгэлтэй гишүүдэд мөн адил ирдэг.

“Мөн эдүгээ, хэрэв миний Эцэгийн хаант улсад надад авчирсан нэг бодгальтай хамт та нар агуу баяр хөөртэй байх аваас, хэрэв та нар олон бодгалийг надад авчрах юм бол та нарын баяр хөөр хэчнээн агуу байх билээ!”

“Болгоогтун, миний сайн мэдээ, мөн миний хад, мөн миний аврал та нарт өмнө чинь байна.

“Миний нэрээр хүлээн авна хэмээх итгэлд итгэн та нар Эцэгээс асуугтун, мөн хүмүүний үрст зүйтэй бүх зүйлүүдийг илэрхийлэх Ариун Сүнс та нарт байх болно” (С ба Г 18:16–18).

Түүнчлэн Ариун Сүнс нь заалгахад бэлэн хүмүүсийг таньж, урихад бидэнд тусалдаг ба Их Эзэн

биднийг хөтлөн чиглүүлэх удирдагчдыг дуудан, тэднийг сургадаг. Тэргүүн Зөвлөлийн 2002 оны хоёрдугаар сарын 28-ны захидалд бишоп болон тойргуудын номлолын ажлын талаар хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлсэн.¹ Тойрог, салбарын зөвлөлийн тусламжтайгаар санваарын гүйцэтгэх хороо нь тухайн нэгжийнхээ номлолын төлөвлөгөөг боловсруулдаг. Тэрхүү төлөвлөгөөндөө номлогчдоор заалгахад бэлэн болсон хүмүүсийг гишүүд хэрхэн олох талаар зөвлөгөө, санаануудыг тусгана. Тойргийн болон салбарын номлолын удирдагчийг дуудах хэрэгтэй бөгөөд уг номлолын удирдагч нь бүрэн цагийн номлогчид болон тэдний сонирхогч нартай нягт харилцаатай ажилладаг.

Танд номлогчдоод заах хүмүүс олж өгөхөд туслах олон арга замууд бий. Хамгийн энгийн арга зам нь хамгийн сайн нь байдаг.

Ариун Сүнсээр удирдуулахын төлөө залбир. Орон нутгийнхаа удирдагчид болон номлогчидтой ярилцан, зөвлөгөө хүсч мөн тэдэнд туслахаа амла. Энэхүү ажилд хамтарч буй хүмүүсийг зоригжуулан дэмж. Ямар ч цагт мөн хэлж, хийж буй бүхий л зүйлдээ Есүс бол Христ бөгөөд Бурхан залбирлуудад хариулдаг гэдгийг гэрчилж бай.

Удирдамж эрэлхийлэн залбирахад Ариун Сүнс та нарыг үнэнийг эрэлхийлж буй хүмүүсийн зүг чиглүүлнэ гэдгийг би гэрчилж байна. Мөн сайн мэдээг зүрх сэтгэлдээ хүлээн авч, итгэлдээ үлдэхээр сонгосон хүмүүстэй хамт та нарын баяр хөөр үүрд байх болно гэдгийг би өөрийн туршлагаас мэдэх билээ.

ЭШЛЭЛ

1. "News of the Church: Ward and Branch Missionary Work Emphasized," *Liahona*, 2002 оны наймдугаар сар, 4-ийг үз.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

- *Teaching, No Greater Call* –д биднийг суралцаж мэдсэн зарчмуудынхаа дагуу амьдрахад нь туслах зорилго тавихыг зааж буй хүмүүстээ урамшуулахыг урьдаг (159-р хуудсыг үз). Зааж буй гэр бүлтэйгээ хамт Ерөнхийлөгч Айрингийн дурьдсан номлолын ажлын адислалуудын талаар ярилцан, сайн мэдээг хуваалцах зорилго тавихад нь тусал.
- Ерөнхийлөгч Айрингийн "хамгийн энгийн арга зам нь хамгийн сайн байдаг" гэсэн зөвлөгөөг санан,

сайн мэдээг хуваалцах арга замуудын талаар гэр бүлтэй ярилц. Санал бодлоо хэрхэн хуваалцах талаар дэлгэрэнгүйг *Teaching, No Greater Call* 160-р хуудсаас үз.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Миний амьдралд тааралдсан номлогчид

Элизабет С.Стайльс

Б и ням гарагт анх номлогч нартай сүмд ирээд багын найзууд болон олон таньдаг хүнтэйгээ тааралдаж билээ. Тэдний дотор сургуулийн маань хамгийн сайн найзуудын нэгийг, бага болон ахлах сургуулийн нарийн бичгүүдийг, урьд нь жаахан муухай харьцаж байсан охиныг, тэр ч бүү хэл шохоорхож байсан залуугаа хүртэл харсан юм.

Эдгээр хүмүүс амьдралын минь туршид мартагдашгүй нөлөө үзүүлсэн юм. Хамгийн сайн найз маань үнэхээр үнэнч шударга залуу эмэгтэй байсан бөгөөд би түүний нөлөөгөөр цаашид Сүмийг сонирхохоор шийдсэн билээ. Сургуулийн нарийн бичгүүд дунд сургуульд байсан үеийг маань санаж байсан нь намайг өөрийгөө чухал хүн гэдгээ мэдрэхэд тусалсан юм. Урьд нь эелдэг бус, муухай харьцаж байсан охин ч гэсэн намайг тэврэн авсан нь бурханлиг хайр болон энэрлийг суралцахад хүргэсэн билээ. Багадаа шохоорхож байсан хөвүүн маань надад гайхалтай сайн жишээ үзүүлсэн бөгөөд түүний гэрлийг би мэдэрч, ойр байхыг хүсдэг болов.

Эдгээр туршлагаудаас би Тэнгэрлэг Эцэг маань намайг номлогчидтой уулзахаас ч өмнө тэдгээр хүмүүсийг илгээн бэлтгэсэн байсан гэдгийг мэдсэн билээ. Бидний хийдэг жижиг зүйлс агуу нөлөө үзүүлж чаддаг гэдгийг, хамгийн чухал нь номлолын ажил надаас эхэлдэг гэдгийг би мэдэж авсан юм.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Сайн мэдээ—хуваалцах бэлэг

Сайн мэдээ гэсэн үг нь Есүс Христ болон Түүний бошиглогчдоор бидэнд өгөгддөг бүхий л сургаал болон ёслолыг хэлдэг. Сайн мэдээ нь Тэнгэрлэг Эцэгээс ирсэн сагс дүүрэн бэлэгтэй адил юм. Энэхүү бэлгийг та бусад хүнд өгч болно. Сайн мэдээний

бэлгийг та хэнтэй хуваалцаж чадах вэ?

Судрын хэсгүүдийг нэг бүрчлэн уншиж сайн мэдээнд өгөгдсөн бэлгүүдийг жагсаан бичих буюу зур.

1. Иаков 5:14–15
2. Мозая 16:6–7
3. З Нифай 18:1–10

4. С ба Г 20:72–73

5. С ба Г 33:16

6. С ба Г 89:4, 18–21

7. С ба Г 132:46

8. С ба Г 137:10

9. С ба Г 138:32–34



Итгэл • Гэр бүл • Халамж

Бүх зүйлийн сэргээлт

Энэ материалыг судалж, гэрээр нь очиж заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд чинь идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Бошиглогч Иосеф Смит, Нийгмийн Халамжийн Бүлгийг Сүмийн амин чухал хэсэг байхаар зохион байгуулсан. Ерөнхийлөгчийн Зөвлөлийн хувьд бид Нийгмийн Халамжийн Бүлэг нь амьдралд чинь яагаад амин чухал болохыг та бүхнийг ойлгоход тусалж чадна гэдэгтэй найдаж байна.

Шинэ Гэрээний эмэгтэйчүүд Есүс Христэд итгэсэн итгэлээ харуулан Түүний ажилд оролцож байсныг бид мэднэ. Лук 10:39 -д “Есүсийн хөлд суун” үгийг нь сонсож байсан Маригийн талаар өгүүлдэг. Иохан 11:27 –д Марта, “Тийм ээ, Эзэн. Та бол Бурханы Хүү болох Христ, ертөнцөд ирэх Нэгэн мөн гэдэгт би итгэсэн гэлээ” хэмээн Христийг гэрчилдэг. Үйлс 9:36, 39 -д сайн үйлсээр баян . . . “Табита хэмээх нэгэн дагалдагчийн талаар . . . бэлэвсэн эмэгтэйчүүд цөмөөрөө хажууд зогсож . . . [түүний] хийдэг байсан цамц, бусад хувцаснуудыг үзүүлж байв . . . хэмээн өгүүлдэг. Ром 16:1–2-д Фойбе “чуулганы үйлчлэгч” бөгөөд “хүмүүсийн туслагч” байв гэж гардаг.

Хожмын үеийн сүмд уламжлагдан ирсэн итгэл, гэрчлэл, үйлчлэлийн загварууд Нийгмийн Халамжийн Бүлэгт илүү зохион байгуулалттай болсон. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Жюли Б.Бек: “Шинэ

гэрээнд Аврагч Мари, Марта нарыг Өөрийнхөө ажилд оролцохыг урьсан шиг энэхүү эрин үеийн эмэгтэйчүүдэд Их Эзэний ажилд оролцох өндөр үүрэг хариуцлага бий хэмээжээ. . . . 1842 онд Нийгмийн Халамжийн Бүлгээс эмэгтэйчүүдийн нэгдмэл байдлыг нэмэгдүүлж Их Эзэний хаант улсыг байгуулахад хүлээх тэдний онцгой үүрэг даалгаврыг биелүүлэх үйл ажиллагааг өрнүүлсэн.¹

Бид итгэл болон хувийн зохистой байдлаа нэмэгдүүлэх, гэр бүлээ бэхжүүлэх мөн гачигдагсаад туслах зэрэгт Нийгмийн Халамжийн Бүлгийн зорилтуудыг анхаарч ажилладаг.

Нийгмийн Халамжийн Бүлэг нь авралын ажлыг дэмжихээр зохион байгуулагдсан гэдгийг би гэрчилж байна. Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч бүхэн энэхүү нандин ажилд чухал үүргийг гүйцэтгэдэг.

Сильвия Х.Оолред, Нийгмийн Халамжийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх.

Судраас

Иоел 2:28–29; Лук 10:38–42;
Ефес 1:10

Бидний түүхээс

Жюли Б.Бек эгч “Нийгмийн Халамжийн Бүлэг нь сэргээлтийн зүй ёсны хэсэг байсан гэдгийг бид Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан мэддэг” хэмээн заасан.²

Сэргээлтийн үйл явц нь 1820 оны Анхны Үзэгдлээр эхэлсэн бөгөөд “шат шатаар, дүрэм дүрмээр” (С ба Г 98:12) үргэлжилсэн. 1842 оны гуравдугаар сарын 17-нд Нийгмийн Халамжийн Бүлэг албан ёсоор анх зохион байгуулагдахад бошиглогч сэргээгдсэн Сүм дэх тэдний чухал байр суурийн талаар цохон тэмдэглэсэн байдаг. Тэрээр, “Эмэгтэйчүүд зохион байгуулагдах хүртэл Сүм хэзээ ч төгс байгаагүй” гэжээ.³

Эшлэл

1. Жюли Б.Бек, “Fulfilling the Purpose of Relief Society,” *Лиакхона*, 2008 оны арваннэгдүгээр сар, 108.
2. Жюли Б.Бек, “Fulfilling the Purpose of Relief Society,” 108.
3. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 451.

Би юу хийж чадах вэ?

1. Би энэ сард Есүс Христийн эмэгтэй дагалдагчдын итгэлийн жишээ болохоор ямар тусламжийг бусдад үзүүлж чадах вэ?
2. Би энэ сард гэрчлэлээ өсгөхийн тулд сэргээгдсэн сайн мэдээний ямар сургаалаас суралцах вэ?

Нэмэлт мэдээллийг
www.reliefsociety.lds.org-ооc үз.

© 2011 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/10. Орчуулгын эхийн зөвшөөрөл: 6/10. *Visiting Teaching Message, February 2011* -ийн орчуулга. Mongolian. 09762 363